МЭДЭЭ · 2022 оны 12-р сарын 6

ЭРҮҮДЭН ШҮҮХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАЛААР ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАВ







Сэлэнгэ аймгийн Прокурорын газраас "Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх нь" сэдвээр хамтарсан зөвлөгөөн зохион байгууллаа.

Зөвлөгөөнд Сэлэнгэ аймгийн Мандал, Сайхан сум дахь сум дундын прокурорын

газрууд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хаалттай хорих 433, 435 дугаар анги, 413 дугаар нээлттэй хорих анги, тус аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Сайхан сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн удирдлагууд болон холбогдох албан тушаалтнууд оролцож, 2022 онд эрүүдэн шүүх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд зохион байгуулсан ажил, түүний үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцсэн байна.

Тодруулбал, прокурорын байгууллагаас улирал бүр Эрүүдэн шүүхийн эсрэг арга хэмжээний талаар сургалт хийх, сэтгэлзүйн тандалт судалгаа авч дүнг тооцох зэрэг ажлыг хамтран хэрэгжүүлэхээр шийдвэрлэжээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2047